МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ХАРИЛЦАА ХОЛБОО,**
**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 1,
Утас: 33-07-90, 33-07-81, Факс: (976-11) 33-07-80
E-mail: info@cita.gov.mn, http://www.cita.gov.mn

2021.07.06 № 01/736

танай ____________-ны № ____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Тус газрын Тогтоол, шийдвэрийн биелэлтийг 2021 оны хагас жилийн байдлаар гарган, хавсралтаар хүргүүлж байна.

ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын 2021 оны 7 дугаар сарын 06 -ны өдрийн
01/736 тоот бичгийн хавсралт

ТУ31739
5202965
1119288568

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
## Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
## 2021 оны хагас жил

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай 2011-06-16 Дугаар 2011.06.16 | 22.2. Энэ хуулийн 22.1.1-д заасан журмыг Засгийн газар батална. /22.1.1 энэ хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйлд заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн санг үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах нийтлэг журмыг боловсруулах;/ | Тус газраас 2021 онд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, журмын төслүүд, Харилцаа холбоо, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрх олгох журмын төслүүдийг боловсруулсан. | 70% | | |
| | 2 | | 7.1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газар нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа – 2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан том | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөөг баталсныг цахим хуудсандаа байрлуулсан. | | | |
| | 3 | | 7.1.2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Олон нийтээс санал, хүсэлт, өргөдөл гомдлыг цахим хуудсаараа https://www.cita.gov.mn/ дамжуулж авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн info@cita.gov.mn цахим шуудang тус газрын Төлөвлөгөө, тайлан, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн хөтөлдөг бөгөөд энэ хаягаар дамжуулан байнга санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. | 100% | | |
| | 4 | | 7.1.3. Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Тус газар нь иргэнд шууд хандсан үйлчилгээ үзүүлдэггүй болно. | 100% Хяналтаас хасуулах | | |
| | 5 | | 7.1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа салбарын хууль тогтоомжууд, бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын мэдээллийг цахим хуудасны "хууль, эрх зүй" дэд цэсэд байрлуулан тухай бүр шинэчлэлт хийж байна. | 100% | | |
| | 6 | | 7.1.5. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | Тус газраас 2021 онд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, журмын төслүүд, Харилцаа холбоо, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрх олгох журмын төслүүдийг боловсруулж нээлттэй санал авахаар байршуулсан. Мөн шинээр боловсруулж байгаа Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх эрх олгох журмын төсөл болон аудит хийх аргачлалын төслийг байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авсан. | 100% | | |